



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 04 16 № 05/3141  
танай 2019 04 12 ны № 01/1082-т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА  
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

*Норцог дүрэм*  
*2019/04/22*

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

Татварын ерөнхий газрын харъяа Завхан аймгийн татварын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Балдандоржийн Галбадрахын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч Б.Галбадрахын хамаарал бүхий этгээд буюу төрсөн дүү Б.Гантөмөр нь тус аймгийн татварын хэлтсийн татварын хяналт шалгалтын татварын улсын байцаагчаар ажиллаж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 “хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол” гэж заасныг зөрчихөөр байна.

Мөн Б.Галбадрах нь Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу холбогдох сонгон шалгаруулалтанд хамрагдаагүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн /шинэчлэн найруулсан/ 27 дугаар зүйлд заасан “төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалт явуулах, төрийн албаны байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилох”-той холбоотой заалтуудыг тус тус зөрчихөөр байна.

Иймд дээрх хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн тухайн албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

*Сүхбаатар*  
*2019.04.16*

*Хашбаатар*  
Х.ХАШБААТАР  
УХА0422 5120829